



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 73

Алтай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн "ж", 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын дүрмийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Мөнхтөр /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Гишүүд: Ч.Жаргалсайхан /Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Д.Баттайван /Хууль, эрх зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

М.Ууган-Эрдэнэ /Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Ж.Гаваа /"Гэгээн нуур" ОНӨҮГ-ын захирал/

С.Ганзориг /ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн/

О.Аюурзана /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны мэргэжилтэн/

Ц.Цээмаа /Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч/

Нарийн бичгийн дарга: З.Мөнхнасан /Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн/

2. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын удирдлага, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, дүрмийг зохих хууль журмын дагуу шинэчлэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж ажиллахыг ажлын хэсэг /А.Мөнхтөр/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

